



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/95

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7, 29.1.11, 29.1.19 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. (COVID-19) коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах байрыг сонгох, бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Тусгаарлах байранд ажиллах алба хаагчдад коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалал, аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулахыг Онцгой байдлын газар (хурандаа М.Адъяабаатар), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт тус тус даалгасугай.

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг холбогдох үүрэг чиглэлээр хангаж, зохион байгуулж буй арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Ганбат)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010281

Аймгийн Засаг даргын 2020 оны  
04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/95 дугаар  
захирамжийн хавсралт

### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

Ажлын хэсгийн ахлагч: Л.Ганбат (Эрүүл мэндийн газрын Эмнэлэгийн  
тусламжийн хэлтсийн дарга)

Гишүүд: Л.Дорждэрэм (Онцгой байдлын газрын Гамшгаас  
хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах  
мэргэжилтэн, хошууч)

Ш.Бямбасүх (Цагдаагийн газрын хэм журмын ажил  
хариуцсан ахлах байцаагч, ахлах дэслэгч)

Н.Мөнгөнцэцэг (Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл  
ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах  
байцаагч)

Б.Хишигсүрэн (Мэргэжилийн хяналтын газрын  
Эмчилгээнмй чанарын хяналтын улсын байцаагч)